ТҮМЭН ШУВУУТ
*Аз жаргалыг үйлдвэрлэнэ*



**Ж.БОЛД**
Гүйцэтгэх захирал

# "ТҮМЭН ШУВУУТ" ХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ II УЛИРЛЫН ТАЙЛАН




# САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

## 2021.II

ТҮМЭН ШУВУУТ®
*Аз жаргалыг үйлдвэрлэнэ*

# ОНЦЛОХ АЖЛУУД

## 2021 ОН

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

## 2021.04.21

Хурлыг цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй байдлаар албан ёсны facebook PAGE хуудсаар шууд дамжуулан зохион байгуулав.











www.tumenshuvuut.mn
70005225




# НОГДОЛ АШИГ

"Түмэн шувуут" ХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр 2020 оны цэвэр ашгийн **40%** буюу **1.6 тэрбум** төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэд 2021 оны 5-р сарын 12-оос эхлэн олгов.



**"ОРГАНИК ХӨГЖИЛ" ХББ -ЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ ГИШҮҮНИЙ ТАНГАРГИЙН БИЧИГ**

**"ОРГАНИК ХӨГЖИЛ" ХББ-ЫН ГИШҮҮН БИ,**

ХҮН, БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ОРГАНИК ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ЭРДЭМ ЧАДЛАА ХАРАМГҮЙ ЗОРИУЛЖ ТӨРИЙН ХУУЛИЙГ ЧАНДЛАН САХИЖ, ҮНЭНЧ ШУДАРГА, ЁС ЗҮЙТЭЙ АЖИЛЛАЖ ДАРААХ ЗААЛТЫГ ЧАНДЛАН МӨРДӨХӨӨ БАТЛАН ТАНГАРАГЛАЯ, ТАНГАРАГЛАЯ ТАНГАРАГЛАЯ.

1. Би, хүнсний үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалтай холбоотой бүхий л үйл ажиллагааг явуулахдаа Органик хүнсний тухай хууль, холбогдох журам, аргачлал, жагсаалт, стандартыг чандлан мөрдөнө.
2. Би, "Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд хэрэглэх бодисын жагсаалт"-д орсноос өөр бодисыг үйл ажиллагаандаа ашиглахгүй.
3. Би, хөрсний үржил шимийг байгальд ээлтэй, хөдөө аж ахуйн тогтвортой зарчим бүхий сэлгээ, компостон бордоо, хучлага таримал тарих болон ногоон бордуурт уринш хэрэглэн нэмэгдүүлнэ.
4. Би, органик хүнсийг бохирдол, халдвараас сэргийлэх зорилгоор хөдөө аж ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
5. Би, зөвхөн баталгаажсан, бүртгэлтэй бүтээгдэхүүндээ органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, "органик" "байгалийн гаралтай цэвэр" "байгалийн цэвэр" гэсэн мэдэгдлийг хэрэглэж, нийтийн хэрэгцээнд нийлүүлнэ.
6. Би, бүтээгдэхүүнээ тариалах, үйлдвэрлэх, хураах, тээвэрлэх, хадгалах, боловсруулах, борлуулах бүхий л шатанд органик бүтээгдэхүүнийг органик бус бүтээгдэхүүнтэй хольж бохирдуулахгүй байх арга хэмжээг авна.
7. Би хамтын баталгаажуулалтын байгууллагынхаа ашиг сонирхол, үнэ цэнийг дээдлэн хүндэлж, хамгаалж, олон нийтэд сурталчлан таниулагч идэвхтэй гишүүн байна.
8. Би, органик үйлдвэрлэлийн зарчим, эрх зүйн шаардлага, техник, технологийн талаарх мэдлэгээ тогтмол сайжруулж, бусадтайгаа мэдлэгээ хуваалцана.
9. Би, хамтран ажиллах гэрээнд заагдсан үйлдвэрлэгч гишүүний эрх, үүргийг чандлан биелүүлнэ.

Миний дээр өгч буй амлалтууд үнэн зөв бөгөөд хяналт, шалгалт, баталгаажуулалтын үед зөвхөн үнэнийг хэлж, хамтарч ажиллах болно гэдгээ батлан тангараглаж байна.

**Тангараг өргөсөн:**

Байгууллага, иргэний нэр Түмэн Шувуут ХК Гарын үсэг:.........

202/_ оны 06 дугаар сарын 03 ны өдөр

# ОРГАНИК БОРДОО

"Түмэн шувуут" ХК-ийн 100% КОМПОСТ БОРДОО үйлдвэрлэл "ОРГАНИК ХӨГЖИЛ ХББ"-д гишүүнээр элслээ.






# "ТҮМЭН ШУВУУТ-2"

## ТӨСӨЛ

Төслийн хүрээнд өндөглөгчийн 2,3,4-р байр барьж ашиглалтад оруулна.

**2021** оны хийж гүйцэтгэх

**БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**

ажлын явц **60%**







www.tumenshuvuut.mn
70005225

# 2021 ОНЫ ТАРИАЛАЛТ



НИЙТ – **1100** га талбайд тариалалт хийв.

**750** га талбайд УЛААНБУУДАЙ тариалав.

**134** га талбайд ЦАРГАС, НОГООН ТЭЖЭЭЛ тариалав.

216 га талбайд РАПС, ОВЪЁОС тариалав.

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛЖ БОЛОХУЙЦ ЦАР ТАХЛЫН ЭРСДЛИЙГ ДАВАН ГАРАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ



Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тасалдал, үнэ ханшийн өсөлт



Ажлын байранд тохиолдсон халдварын үеийн эрсдэл



Хөл хорионий үед үйл ажиллагааны саатал гарах эрсдэл

## ЭРСДЭЛ БАГАТАЙ ДАВАН ТУУЛАХ



-Тэжээлийн түүхий эдийн нөөц бүрдүүлэв



-Халдвар хамгааллын дэглэм сахиулж ажиллав
-Ажилтнуудаа вакцинд 100% хамруулав
-Ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж гүйцэтгэж байна.




-Борлуулалт, санхүүгийн албаны ажилтнууд үүлэн технологи ашиглан гэрээсээ ажиллах, мэдээллээ илгээх боломжтой болов.

# Та бүхэнд амжилт хүсье!

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!